

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Нэг. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан нийт зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын саналыг нэгтгэн сангийн яаманд хүргүүлж Сангийн сайдын 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн “Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг батлах, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай” 06 дүгээр тушаалаар шийдвэрлүүлээ.

Тус хөтөлбөрийн дагуу ГЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/123 тоот тушаалаар “Гаалийн ерөнхий газар болон дэргэдэх байгууллагуудын зохион байгуулалтын бүтэц, орон тоо”- /ГЕГ-ын 25, харьяа газар, хороо-19/-г шинэчлэн баталсан.

2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт ТТ-1932, ТҮ-534 буюу 2466 байхаар баталснаас Төрийн тусгай-1480, Төрийн үйлчилгээний-443 буюу 1923 албан хаагч ажиллаж байна.

Гаалийн байгууллагад шинээр ажилд орсон-91, суралцах болон эрүүл мэндийн шалтгаанаар ажлаас чөлөөлж нөөцөд бүртгэсэн-1, өндөр насны тэтгэвэрт-13, хүүхэд асрах чөлөө-39, нас барсан-4, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн-11, гаалийн албанаас халагдсан-5 тус тус байна.

Сангийн сайдын 2024 оны “Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 6 дугаар тушаал, Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны “Бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/123 дугаар тушаал, Сангийн сайдын 2023 оны 135 дугаар тушаалыг үндэслэн нийт албан хаагчдын албан тушаалын зэрэглэл өөрчлөгдсөн тул Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор батлуулсан Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх шаардлага бий болсон эдгээртэй холбогдуулан Гаалийн байгууллагын стратеги төлөвлөгөөг үндэслэн чиг үүргийг нь өөрчлөхөөр нэгж, байгууллагуудаас саналын жагсаалтыг гаргахад шинээр боловсруулан батлуулах 31, чиг үүрэг өөрчлөх шаардлагатай 72, өөрчлөлт орохгүй 60 нийт 163 албан тушаалын тодорхойлолтуудын өөрчлөлтийг оруулахаар боловсрууллаа.

Сангийн сайдын дэмжлэг, ГЕГ-ын удирдлагын дэмжлэгтэйгээр Гаалийн тухай хуулийн 280 дугаар зүйлийн 280.7 дэх хэсэгт Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас олгоно гэж оруулж УИХ-аар батлуулсан.

Энэ хүрээнд энэ оны 04 дүгээр сараас хойш Хүний нөөцийн хэлтэс, Санхүү хөрөнгө оруулалтын газар, харьяа газар хороод хамтран судалгаа хийж

ажиллаа. Тухайлбал болзол хангасан албан хаагчдын тоо гаргах/ анх тоо гарсан/, тасралтгүй ажилласан байх, нийгмийн даатгал төлсөн эсэхийг нягтлах замаар имонголиа лавлагаа гаргуулах, ажилласан жилийг тооцох холбогдох журмыг судлах, холбогдох мэргэжлийн газраас чиглэл авах, албан хаагчдаас хүсэлт тайлбар авах зэрэг ажиллагааг хийж хууль хэрэгжиж эхлэх хугацаанд олговол зохих тоог гаргаж СХОГ-т хүргүүлж, мөн дээрх хугацаа тоологдох буюу үргэлжлүүлэн тооцож олгох ажиллагаа хийгдэж байна.

Тайлант хугацаанд нийт 482 албан хаагчид 6.7 тэрбум төгрөгийн тэтгэмж олгож шийдвэрлээд байна.

“Гаалийн байгууллагын албан хаагчийн 2024-2029 оны Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулах явцад хууль, эдийн засгийн үндэслэлийг судалж Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 3-т “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”, Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 1-д “Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино”, 55 дугаар зүйлийн 55.3-т “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасан тул дээрх хөтөлбөрийг “Гаалийн байгууллагын албан хаагчийн 2024-2029 оны сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” болгон дахин өөрчилж боловсруулж удирдлагад танилцуулахаар бэлтгэв.

Хөтөлбөрийг боловсруулах явцдаа Сангийн яам, Гадаадын иргэн харьяатын газар, Барилга хөгжлийн төв, Төрийн тусгай албан хаагчдын эмнэлгийн хөтөлбөрүүдийг судлан харьцуулсан ба Олон Улсын Валютын Сангийн орлогын удирдлагын зөвлөх Барбара Хеберт гаалийн байгууллага дээр ажиллах үед хөтөлбөрийн төслийг танилцуулан, зөвлөмж авч ажиллаж, төслийг газар, хороодод 2 удаа хүргүүлж, саналуудыг авч нэгтгэн тусгасан.

Хөтөлбөрийн зорилго нь Гаалийн байгууллагын албан хаагчийн ур чадвар, хөгжил, гүйцэтгэлийг сайжруулах, нийгмийн баталгааны түвшин нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх үйл ажиллагааны явцад эрүүл мэнд, амь насыг нь хамгаалах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн болно.

Мөн "Гаалийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-ийн төслийг боловсруулан, Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодоос санал авч, саналыг нэгтгэж байна.

Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны А/367 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн шилжүүлэн ажиллуулах журам”-ын цахим аргачлалын программын даалгаврыг Мэдээлэл технологийн

газарт хүлээлгэн өгч, тус газартай тайлангийн хугацаанд 2 удаа нэмэлт санал солилцож хамтарсан уулзалт хийж ажиллаа.

Уг журмын хүрээнд энэ оны 04 дүгээр сарын 20-26-ны хооронд захиргаа, дотоод ажлын систем (CERP)-ээр “Б”, “В” бүсэд ажиллаж буй албан хаагчдаас шилжих болон үргэлжлүүлэн ажиллах эсэх хүсэлтийг хүлээн авч холбогдох ажиллагааг хийж удирдлагад танилцуулсан. Тухайлбал: Гаалийн байгууллагын “Б”, “В” бүсэд хамаарах 15 гаалийн газар, хорооноос нийт 14 газар, хорооны 147 албан хаагч хүсэлт ирүүлснээс “Б” бүсийн 69 албан хаагч, “В” бүсийн 8 албан хаагч, нийт 77 албан хаагч үргэлжлүүлэн ажиллах, “Б” бүсийн 32, “В” бүсийн 38 албан хаагч, нийт 70 албан хаагч өөр гаалийн газар, хороодод шилжих хүсэлт ирүүлсэн харин “Б”, “В” бүсэд 15 гаалийн газар, хороод багтах бөгөөд одоо ажиллаж байгаа 597 төрийн тусгай албан хаагчдын 25% буюу 147 албан хаагч үргэлжлүүлэн ажиллах эсвэл харьяа гаалийн газар, хороодод шилжих хүсэлт ирүүлсэн бол “Гаалийн улсын байцаагчийн шилжүүлэн ажиллуулах журам”-ын 3.4-т “Б”, “В” бүсэд ажиллаг хугацааг 3 хүртэлх жилээр өөрийн хүсэлтээр сунгаж болно” гэсэн заалтын дагуу үргэлжлүүлэн ажиллах хүсэлт гаргасан 77 албан хаагчийн хүсэлтийг хангах боломжтой байна.

Замын-үүд дэх гаалийн газрын үйл ажиллагааг 24 цагийн горимд шилжүүлсэнтэй холбоотойгоор бүтэц, орон тоог нэмэгдүүлсэн бөгөөд тус орон тоог тусгай шалгалтаар нөхөхийн зэрэгцээ дээрх журмын Б,В бүсэд ажилласан болзол хангаж хүсэлт гаргасан албан хаагчийг судалж, шилжүүлэн томилохоор ажиллаж байна.

Мөн уг журмын хүрээнд эхний хагас жилд нийт 171 албан хаагчийг харьяа газар, хороодод шилжүүлэн томилсон ба энэ нь нийт албан хаагчдын 11.5 хувь байгаа бөгөөд 2024 онд хийгдсэн ГЕГ-ын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, албан хаагчийн гаргасан хүсэлт, үүссэн сул орон тоо, ажил мэргэжлийн онцлог, ажлын ачааллыг харгалзан шийдвэрлэсэн байна.

Гаалийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх, байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, сургалт судалгааны чиглэлээр хамтран ажиллах, мэргэжилтнийг сургаж бэлтгэх, чадавхжуулахад хамтран ажиллахаар энэ оны 01 болон 04 дүгээр сард “Гаалийн ерөнхий газар-Монгол улсын их сургууль”, “Гаалийн ерөнхий газар- Хөдөө, аж ахуйн их сургууль”- хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.

Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажиллаа. Үүнд:

Төрийн албаны тухай хуулийн 27.1, 44.5, 44.1, 46, 60.1, 47 дэх, Хөдөлмөрийн тухай хуулийн 100,139, 137 дахь заалтууд болон эдгээр хуулиудад нийцүүлсэн гаргасан холбогдох журмаар гаалийн байгууллагын сул орон тоог нөхөх, сэлгэн болон шилжин ажиллуулах, ажилд томилох, чөлөөлөх, чөлөө олгох, албанаас халах,

тусламж тэтгэмж олгох зэрэг албан хаагчтай холбоотой асуудлыг шийдвэрлэж байна.

Авлигын эсрэг хуулийн 10.3. Гаалийн байгууллага нийт 1,447 албан хаагчийн 2023 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд бүрэн мэдүүлж, тайланг нэгтгэн энэ оны 02 дугаар сарын 26-ны өдөр 01/714 дугаартай албан бичгээр АТГ-т хүргүүлэв.

Мөн энэ хуулийн 10.4. Тайлангийн хугацаанд 3 албан хаагч их хэмжээний өөрчлөлт мэдүүлж, цахим санд баталгаажуулав.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай:

Тайлангийн хугацаанд тус хуулийн 23.1-д заасны дагуу гаалийн байгууллагад томилогдохоор нэр дэвшсэн 317 албан хаагчийн ХАСУМ-ийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, 274 албан хаагчийн хариуг хүлээн аваад байна.

ХАСУМ-ийн хариугаар зөрчил үүссэн 3 албан хаагч, иргэний 2-г томилохоос татгалзаж, 1 албан хаагчийг ашиг, сонирхлын зөрчил үүсэхээр нөхцөл байдал үүссэн тухай бүр мэдэгдэл, тайлбар гаргаж ажиллах талаар мэдэгдэн албан тушаалд томилсон. Дээрх зөрчил үүссэн гэж ирсэн 1 албан хаагчийн хувьд төрсөн дүү нь ажилладаг гэсэн үндэслэл байсан бөгөөд тухайн 2 албан хаагч бүтцийн 2 өөр нэгжид ажиллах, нэг нэгнийхээ үйл ажиллагаанд шууд хяналт тавихгүй тул томилох шийдвэр гаргасан болно.

ХАСУМ-ийн хариугаар зөрчил үүсэж болзошгүй талаар анхааруулсан 12 албан хаагч, иргэний асуудлыг судалж, 2 иргэн, албан хаагчийг томилохоос татгалзаж, 10 албан хаагч иргэнд ашиг, сонирхлын зөрчил үүсэхээр нөхцөл байдал үүссэн тухай бүр мэдэгдэл, тайлбар гаргаж ажиллах талаар мэдэгдэн албан тушаалд томилсон байна.

Мөн шинээр томилогдож байгаа ажилтнаас үйл ажиллагаандаа ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах баталгааны хуудсыг гаргуулан авч ажиллаж байна.

Захиргааны ерөнхий хуулиар Захиргааны шийдвэр, албан хаагчдын хүний нөөцийн томилолт, чөлөөлөлттэй холбоотой асуудлаар тухай бүр сонсох ажиллагааг хийж, оролцогчийн саналыг тусгаж байгаа бөгөөд захиргааны шийдвэрийн төсөлд үндэслэл хэсгийг тусган төслийг хянах албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаараа мэдэгдэн гарын үсэг зурж баталгаажуулж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар Гаалийн ерөнхий газар болон дэргэдэх байгууллагын төрийн тусгай болон төрийн үйлчилгээний батлагдсан болон ажиллаж байгаа албан хаагчдын орон тооны мэдээллийг shilendans.gov.mn-д сар бүрийн 8-ны дотор байршуулав.

Гаалийн ерөнхий газар болон харьяа 19 газар, хороодын төрийн тусгай болон төрийн үйлчилгээний батлагдсан болон ажиллаж байгаа, хүүхэд асрах чөлөөтэй

албан хаагчдын орон тооны мэдээллийг 1,2-р улирлын мэдээг гарган Статистик, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлж ажиллаа.

Гаалийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд “Гаалийн байгууллагад шинээр ажилд ороход тавигдах шаардлага”- хэсэгт бусад төрийн тусгай чиг үүргийн байгууллагад тавигддаг шаардлагатай уялдуулан боловсруулж, төслийг Хуулийн хэлтэст хүргүүлэв.

”Гаалийн улсын байцаагчид цол олгох, хураах, сэргээх журам”-ын бүх хэсэгт зохицуулалтыг тодорхой болгох, агуулга найруулгын өөрчлөлт оруулахаар харьяа газар, хороодоос 116 санал ирүүлснийг нэгтгэж, Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэв.

2024 онд Гаалийн байгууллагын төрийн тусгай албан тушаалын нийт 1,447 албан хаагчийн ХАСХОМ мэдүүлсэн талаарх тайланг нэгтгэн энэ оны 02 дугаар сарын 26-ны өдөр 01/714 дугаартай албан бичгээр АТГ-т хүргүүлэв.

Гаалийн ерөнхий газар болон дэргэдэх байгууллагын албан хаагчдын энэ оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс хойш шилжин болон дэвшин томилогдсон 84 албан хаагчийн ХАСХОМ-г шинээр нээж, мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлэх ажлыг зохион байгуулав.

Гаалийн байгууллагад шинээр болон шилжин дэвшин томилогдохоор нэр дэвшүүлсэн 311 албан хаагчийн ХАСУМ-г шинээр нээж, бүртгэл хөтлөн холбогдох материалын хамт 53 удаагийн албан бичгээр АТГ-т хянуулан томилолтын асуудлыг шийдвэрлүүлэв.

Албан хаагчийг сургаж чадавхжуулахаар Удирдлагын академид энэ оны 01 дүгээр сард ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 31, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 8 албан хаагчийг /хувийн зардлаар/ сургах хүсэлтийг хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтээр 2, хувийн зардлаар 25 үүнээс ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 19, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 6 буюу нийт 27 албан хаагч суралцлаа.

Хүний нөөцийн чиглэл хариуцсан албан тушаалтнуудын ажлын ачаалал, ажиллах нөхцөл, тулгамдсан асуудлыг тодорхойлох, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөлт хийх, цаашид энэ чиглэлийн албан хаагчдыг тогтвортой ажиллуулах бодлогын баримт бичигт шаардлагатай зохицуулалтыг тусгах, гадаад, дотоодын сургалтад хамруулах, оролцоог хангах зорилгоор гүүглэ формоор судалгааг авч нэгтгэв.